



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН ТӨСВИЙН 2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ОМА-2024/18-15-ШТА-ГА

ӨМНӨГОВЬ АЙМАГТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2023 ОНД
ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ БАТЛАГДААГҮЙ БАЙНА.

Даланзадгад хот 2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер Т.Хонгорзул
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Шижирболд
Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn
Аудитор Э.Бат-Эрдэнэ
Утас: 70533552 Цахим хаяг: baterdennee@audit.gov.mn
Аудитор Г.Амарзаяа
Утас: 70533552 Цахим хаяг: Amarzaya@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар
авна уу: Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлал.....	2
Хүснэгтийн жагсаалт.....	2
Зургийн жагсаалт.....	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх.....	3
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	4
БҮЛЭГ 1. ӨМНӨГОВЬ АЙМАГТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ХИЙХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.....	6
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД ТУСГААГҮЙ БАЙНА.....	7
БҮЛЭГ 3. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ АШИГЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.....	7
ДҮГНЭЛТ.....	10
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	11

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ШТА	Шууд тайлагнах аудит
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХХК	Хариуцлагат хувьцаат компани

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	<i>Баталсан төсөл, арга хэмжээ</i>	4
Хүснэгт 2	<i>2023 онд эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээ</i>	6
Хүснэгт 3	<i>2023 онд эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний олгосон санхүүжилт</i>	7
Зураг 1	<i>Төрийн албан хаагчдын орон сууцны 14 айл</i>	8
Зураг 2	<i>Цогтцэций сумын сургуулийн барилга</i>	9

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилго

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн эсэх?
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж хүлээн авсан эсэх?
- Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх?

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Өмнөговь аймагт 2023 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол улсын аудитын стандарт MNS 6817-5:2020, гүйцэтгэлийн аудитын зарчим MNS 6817-6:2020, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад асуудлын шинжилгээний дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- “Алсын хараа” 2050 Монгол Улсын урт хугацааны урт хугацааны хөгжлийн бодлого,
- Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”,

- Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Шижирболд, аудитор Э.Бат-Эрдэнэ, Г.Амарзаяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд Өмнөговь аймагт он дамжин хэрэгжих 11, шинээр хэрэгжих 1 нийт 63,196.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл, арга хэмжээг тайлант онд 45,357.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Үүнээс 2023 онд эрх шилжин санхүүжих 576.8 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ байна.

Хүснэгт 1 Баталсан төсөл, арга хэмжээ

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Шинэ, шилжих	Эрх шилжсэн эсэх /тийм, үгүй/	Хугацаа		Төсөвт өртөг /сая. төгрөг/	2023 онд санхүүжих дүн /сая. төгрөг/
						Эхлэх	Дуусах		
1	IV.4.4	Хот, суурин газрын ус хангамжийн эх үүсвэрийн нөөц тогтоох судалгаа, хайгуул /Говь-Алтай, Төгрөг сум, Дундговь, Эрдэнэдалай сум, Дорноговь, Дэлгэрэх сум, Өмнөговь, Сэврэй сум/	ТЭЗҮ	шилжих	үгүй	2023	2023	3,000.0	59.2
2	IX.1.54	Төрийн албан хаагчдын орон сууцны барилга, 14 айл /Өмнөговь, Баян-Овоо сум/	Барилга байгууламж	шилжих	тийм	2021	2023	529.0	333.3
3	X.1.1.38	Сургуулийн спорт заалны барилга /Өмнөговь, Булган сум/	Барилга байгууламж	шилжих	тийм	2019	2023	1,000.0	116.2
4	X.1.1.53	Багшийн хөгжлийн төвийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	Барилга байгууламж	шилжих	тийм	2020	2023	5,443.2	127.3
5	X.1.1.272	Дотуур байрны барилга, 120 ор /Өмнөговь, Даланзадгад сум/	Барилга байгууламж	шилжих	үгүй	2023	2023	2,274.2	1,923.9
6	XI.1.52	Аймгийн номын сангийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	Барилга байгууламж	шилжих	үгүй	2022	2024	4,200.0	2,936.7
7	XII.1.2.7	Улсын чанартай хатуу хучилттай авто замын их засвар /Өмнөговь, Дундговь, Өвөрхангай, Баянхонгор, Төв, Хэнтий/	Их засвар	Шинэ	үгүй	2023	2023	35,552.5	35,552.5
8	XIII.3.17	Малчид болон орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн тоног төхөөрөмж /Өмнөговь, Баяндалай, Мандал-Овоо, Ханхонгор, Ханбогд, Номгон, Манлай, Баян-Овоо, Сэврэй, Ноён, Цогтцэций, Булган сум/	Тоног төхөөрөмж	шилжих	үгүй	2023	2024	1,650.0	400.0
9	XV.1.23	Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Өмнөговь, Манлай сум/	Барилга байгууламж	шилжих	үгүй	2021	2023	1,517.0	474.5

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

10	XV.1. 29	Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Өмнөговь, Номгон сум/	Барилга байгууламж	шилжих	үгүй	2021	2023	1,527.8	318.1
11	XV.1. 41	Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Өмнөговь, Сэврэй сум/	Барилга байгууламж	шилжих	үгүй	2022	2023	1,650.0	2,515.8
12	XV.1. 85	Сэргээн засах эмнэлгийн барилга, 40 ор /Өмнөговь, Даланзадгад сум, 6 дугаар баг/	Барилга байгууламж	шилжих	үгүй	2023	2024	4,692.0	600.0
		Нийт						63,196.2	45,357.5

Эх сурвалж: Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль

Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээнд олгох санхүүжилтийн 20.6 хувийг барилга, байгууламж, 78.4 хувийг их засвар, 0.9 хувийг тоног төхөөрөмж, 0.1 хувийг ТЭЗҮ-д зарцуулахаар төлөвлөсөн байна.

Өмнөговь аймагт 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хийх төсөл, арга хэмжээ Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд батлагдаагүй байна.

БҮЛЭГ 1. ӨМНӨГОВЬ АЙМАГТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ХИЙХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлсэн жагсаалтыг аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 01/992 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

1.2 Тус жагсаалтаар 239,445,5 сая төгрөгийн өртөгтэй 23 төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр санал хүргүүлсэн боловч нэг ч төсөл, арга хэмжээ батлагдаагүй байна.

1.3 Харин Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжсэн 3 төсөл, арга хэмжээнд 576.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тусгагдсан байна.

Хүснэгт 2 2023 онд эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээ

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Шинэ, шилжих	Хугацаа		Төсөвт өртөг /сая.төгрөг/	2023 онд санхүүжих дүн /сая.төгрөг/
					Эхлэх	Дуусах		
1	IX.1.54	Төрийн албан хаагчдын орон сууцны барилга, 14 айл /Өмнөговь, Баян-Овоо сум/	Барилга байгууламж	шилжих	2021	2023	1,388.9	333.3
2	X.1.1.38	Сургуулийн спорт заалны барилга /Өмнөговь, Булган сум/	Барилга байгууламж	шилжих	2019	2023	1,714.6	116.2
3	X.1.1.53	Багшийн хөгжлийн төвийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	Барилга байгууламж	шилжих	2020	2023	4,625.5	127.3

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

1.4 Дээрх төсөл, арга хэмжээнүүд нь 2019-2021 онуудад эхлэн, 2021-2022 онуудад ашиглалтад хүлээн авсан барилгууд бөгөөд Улсын Их хурлын 2021 оны 88 дугаар тогтоолын дагуу үнийн өсөлтийн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажиж төсөвт өртөг нэмэгдсэн байна.

1.5 Өмнөговь аймгийн улсын төсөвт төвлөрүүлэх орлого жил бүр нэмэгдсээр байхад улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээ буурсаар байгаа нь уул уурхайгаас орсон орлого бүс нутагтаа үр нөлөөгөө өгөхгүй байгааг харуулж байна.

1.6 Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 1а/297 дугаар, Барилга, хот байгуулалтын яамны 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 2/574 дугаар албан бичгүүдээр аймгийн Засаг даргад гэрээнд өөрчлөлт оруулж ажиллах чиглэл хүргүүлсэн байна.

1.7 Чиглэлийн дагуу аймгийн Засаг дарга захирамж гарган 2023 оны 02 дугаар сарын 15-н өдөр үндсэн гэрээнүүдэд нэмэлт, өөрчлөлт байгуулж санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт 3 2023 онд эрх шилжиж ирсэн төсөл, арга хэмжээний олгосон санхүүжилт

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Гүйцэтгэгчийн нэр	2023 онд санхүүжих дүн /сая төгрөг/	2023 онд олгосон дүн /сая төгрөг/
1	IX.1.54	Төрийн албан хаагчдын орон сууцны барилга, 14 айл /Өмнөговь, Баян-Овоо сум/	Барилга байгууламж	Гээт ХХК	333.3	333.3
2	X.1.1.38	Сургуулийн спорт заалны барилга /Өмнөговь, Булган сум/	Барилга байгууламж	Шинэ соёл констракшн ХХК	116.2	116.2
3	X.1.1.53	Багшийн хөгжлийн төвийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	Барилга байгууламж	Хүннүгийн говь ХХК	127.3	127.3

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

1.8 Батлагдсан төсвийг төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч компаниудад аймгийн Засаг даргын захирамжаар барьцаа хөрөнгийг суутгаж гэрээний хугацаанд шилжүүлсэн байна.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД ТУСГААГҮЙ БАЙНА.

2.1. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн “Багшийн хөгжлийн төвийн барилга”, Булган сумын “Сургуулийн спорт заал”-ны барилгуудыг 2021 онд, Баян-Овоо сумын “Төрийн албан хаагчдын орон сууцны 14 айл”-ын барилгыг 2022 онд улсын комисс ажиллан хүлээн авсан байна.

2.2. Багшийн хөгжлийн төвийн барилгыг Боловсрол, шинжлэх ухааны газар, Булган сумын сургуулийн спорт заалны барилгыг Булган сумын сургууль, Баян-Овоо сумын Төрийн албан хаагчдын 14 айлын орон сууцыг Өмнөговь Гурвансайхан орон сууцны корпорац тус тус хөрөнгийн бүртгэлдээ тусгасан байна.

2.3. Харин Монгол Улсын Их хурлын 2021 оны 88 дугаар тогтоолын дагуу үнийн өсөлтийн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажиж төсөвт өртөг нэмэгдсэн дээрх төсөл арга хэмжээнүүдийн 2023 онд нэмэгдсэн 576.3 сая төгрөгийг нэмж бүртгээгүй байна.

2.4. Аймгийн Засаг даргын захирамжид өмчийн бүртгэлд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газарт үүрэг болгосон боловч өмчийн бүртгэлд хяналт хийгээгүй байна. Иймд төсөвт өртгийг нэмж бүртгүүлж зөрчлийг арилгах албан шаардлагыг Орон нутгийн өмчийн газарт хүргүүллээ.

БҮЛЭГ 3. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ АШИГЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

3.1 Багшийн хөгжлийн төвийн барилга, Булган сумын сургуулийн спорт заалны барилгыг 2021 онд ашиглалтад орсноос хойш зориулалтын дагуу ашиглаж байна.

3.2 Харин Баян-Овоо сумын “Төрийн албан хаагчдын орон сууцны 14 айл”-ын барилгыг 2022 оны 12 дугаар сарын 14-ны өдөр Өмнөговь Гурвансайхан орон сууцны корпорац хүлээн авснаас хойш ашиглаагүй байна.

3.3 Шалтгаан нь барилгыг хүлээн авснаас хойш ашиглах хугацаанд дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Гадна талын зарим хэсэг өнгөө алдсан, халцарсан,
- Зарим хаалга гажсан, цоож эвдэрсэн,

- Ихэнх өрөөний дотор хагарал үүссэн,
- Тааз хананы заагаар шороо, тоос ордог,
- Паркет шаланд зай завсар үүссэн, хөндийрсөн байна.

Зураг 1 Төрийн албан хаагчдын орон сууцны 14 айл



3.4 “Өмнөговь Гурвансайхан орон сууцны корпорац” ХХК-ны төлөөлөн удирдах зөвлөл 2024 оны 02 дугаар сарын 01-ны өдөр хуралдаж дээрх зөрчлийг барилга, байгууламжийн ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа дуусаагүй тул Барилгын тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.6-т “Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж,

тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна” гэж заасны дагуу гүйцэтгэгчийн зардлаар засвар хийлгэхээр шийдвэрлэсэн байна.

3.5 Баян-Овоо сумын “Төрийн албан хаагчдын орон сууцны 14 айл”-ын барилга ашиглалтад 2022 онд орсон хэдий ч өнөөдрийг хүртэл ашиглахгүй байгаа нь төсвийн хөрөнгө оруулалт үр дүнгүй, үр ашиггүй байгааг харуулж байна.

3.6 Иймд улсын төсвийн хөрөнгөөр хийсэн төсөл, арга хэмжээг хүлээн авч байгаа улсын комиссын гишүүдийн ажлын хариуцлагыг нэмэгдүүлэх, хариуцлага алдсан албан хаагчдад хариуцлага тооцож байх шаардлагатай байна.

3.7 Өмнөх оны аудитын тайланд тусгасан улсын төсвийн хөрөнгөөр 2019 оноос хойш хийгдэж байгаа Цогтцэций сумын 960 хүүхдийн сургуулийн барилгын ажил гүйцэтгэгч компаниас шалтгаалан 2023 онд мөн ажил хийгдээгүй орхигдсон хэвээр байна.

Зураг 2 Цогтцэций сумын сургуулийн барилга



ДҮГНЭЛТ Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Иргэдийн хэрэгцээ шаардлага, санал хүсэлтийн дагуу эрэмбэлсэн төсөл, арга хэмжээний санал улсын төсөвт тусгагдаагүй байна.
- Төсөвт өртөг нэмэгдсэн 3 төсөл, арга хэмжээний нэмэгдсэн төсвийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.
- Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.
- Өмнөх аудитын тайланд тусгасан 2019 оноос хойш хийгдэж байгаа Цогтцэций сумын 960 хүүхдийн сургуулийн барилгын ажил гүйцэтгэгч компаниас шалтгаалан 2023 онд мөн ажил хийгдээгүй орхигдсон хэвээр байна.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 1108

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар болон Өмнөговь аймгийн Засаг даргад тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Шижирболд)-т үүрэг болгосугай.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Шижирболд)-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

016010007

